



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар A/146

Арвайхээр сум

**Хууль тогтоомжийн хэрэгжилтийг
хангаж ажиллах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн цэгийн тоог шинэчлэн батлагдах хүртэл хугацаанд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгохыг түр хугацаагаар хориглосугай.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумдын нутаг дэвсгэрт холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, дээрх шийдвэрийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (А.Отгонцэцэг)-т, сумын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0250

D:My Doc. Zahiramj. Zasag darga